

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ
ЭХНИЙ 5 САРЫН БАЙДЛААРХ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Эрүүл мэндийн газар.

2022.05.09

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
					Он	Түвшин			
1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
1	<u>Зорилго</u> Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.	2021-2024	Улсын төсөв 1,602,3 Хандив тусламж 20,9 сая	Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалтын хувь	2021	82	83	Коронавируст халдварт өвчний үед эм, эмнэлгийн хэрэгслийн 17 нэр төрлийн 5-10 хоногийн нөөцтэй байна. Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалт 85,1, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 86,6 хувьтай байна.	100
1.1	<u>Зорилт</u> Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.	2021-2024	Улсын төсөв 1,602,3 Хандив тусламж 20,9 сая	Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ (сая.төг)	2021	4,840,0 сая	435,0 сая	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 1,622,0 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
1.1.1	<u>Арга хэмжээ:</u> Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх.	2021-2024	-	Эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтын хувь	2021	100	100	2022 оны 10 дугаар сард хийгдэнэ.	ХБ
1.1.2	<u>Арга хэмжээ:</u> Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу	2021-2024	Улсын төсөв 400,0 сая Хандив тусламж 20,9 сая	Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2021	85,3	85,9	Аймгийн хэмжээнд гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалт 83,6 хувьтай байна.	100

	арга хэмжээний бэлэн байдлыг хангах.							2022 оны эхний 5 сарын байдлаар Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 2704 бүртгэгдэж өссөн дүнгээрээ 15122 болсон байна. 2704 тохиолдлын ойрын хавьтал 3147 хүнд тандалт судалгааг хийн, 1, 2-р хавьтлын хүнийг илрүүлэн хяналтад авч, түргэвчилсэн шинжилгээ болон баталгаажуулах шинжилгээнд хамрууллаа. Өнөөдрийн байдлаар гэрийн ажиглалт болон эмчлэгдэж байгаа хүн байхгүй байна. Коронавирусын халдварын тархалтын түвшин “Халдварын тархалт бага буюу ногоон” түвшинд байна. Томуугийн харуулдан тандалтын 2022 оны 17 дугаар 7 хоногийн мэдээгээр аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөл амбулаторийн үзлэгт 10,4%, дуудлагын үзлэгт 22.1%-тай байна. Сүүлийн 5 долоо хоногт томуу томуу төст өвчлөл тогтвортой буурч амбулаторийн үзлэгт 13,9%-иар, дуудлагын үзлэгт эзлэх 26,9%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын үед хэрэглэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 83,6%, эмийн хангалтын хувь 86,6 хувь байна.	100
1.1.4	<u>Арга хэмжээ:</u> Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах.		-	Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо	2021	50	55	Гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээллэх дохиоллоор ажиллах дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны штаб, мэргэжлийн ангиуд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, газар хөдлөлтийн гамшгийн үеийн аврах ажиллагаа эмнэлгийн тусламжийн	

								чиглэлээр дадлага сургалт хийлээ. Тухайн үйл ажиллагаанд нийт 82 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдаж, түргэн тусламжийн 3 авто машин цуглах талбайд бэлэн жагслаа.	
			-	Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн тоо бүрэлдэхүүний тоо	2021	1	2	Эрүүл мэндийн албаны штаб, Мэргэжлийн ангийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, аранзны үзлэгт хамрагдан, мэргэжлийн 2 ангийг сурган дадлагажууллаа.	100
2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
2.1. Эрүүл мэнд									
2.1	<u>Зорилго</u> Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ.	2021-2024	-	Хүн амын дундаж наслалт (тоо)	2021	74,61	74,5	Аймгийн хүн амын дундаж наслалт 74.61 байна.	100
				эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү (тоо)	2021	7,54	7,7	Эрэгтэй хүний дундаж наслалт 71.48, эмэгтэй хүний дундаж наслалт 79.28 болж дундаж наслалтын зөрүү 7.54 байна.	100
2.1.1	<u>Зорилт</u> Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ.	2021-2024	ЭМД-ын сан	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	2021	64,95	65,0	2022 оны эхний 4 сарын байдлаар зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12073 иргэнээс 2654 буюу (22%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12974 иргэн хамрагдахаас 2701 буюу (20,8%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2568 иргэн хамрагдахаас 592 буу (23,1%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8398 иргэн хамрагдахаас 1240 буюу (14,8%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 20,2%-тай байгаа нь өнгөрсөн оны	50

								мөн үеэс 1,6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 26, чихрийн шинжинтэй 4 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авлаа.	
2.1.1.1	Арга хэмжээ: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр “эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулах	2021-2022	УТ 1,5 тэрбум	Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	2021	0	1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж ашиглалтад орууллаа.	100
2.1.1.2	Арга хэмжээ: Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх.	2021-2024	-	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо	2021	38	39	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр”, “Эрүүл мэндээ дээдлэгч өрх, гэр бүл, иргэн” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 211 тоот албан бичгээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргүүллээ. Шалгаруулалтыг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулна.	ХБ

2.1.1.3	<p><u>Арга хэмжээ:</u> Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах.</p>	2021-2024	ЭМДС 5,3 сая	Зорилтот бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалтын хувь	2021	48	49	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар шинэчилэгдсэн “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо”-ны журмыг хэрэгжүүлэх хүрээнд харьяа эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн 3 удаагийн цахим хурлаар, 6 удаагийн албан бичгээр ажлын чиглэл, зөвлөмжийг өглөө. Насанд хүрэгчдийн багц үзлэг болон хүүхдийн үзлэгийг зохион байгуулах эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран график сургалтад бүрэн хамруулж чадавхжууллаа.</p> <p>Зорилтот насны иргэдийг хамруулах үзлэгийн үйл ажиллагааны нээлтийг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлж одоогийн байдлаар нийт 38 хүнийг хамруулаад байгаа бөгөөд хамрагдвал зохих иргэдийн 0,1 хувийг эзэлж байна.</p>	10
				Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь	2021	42,8	33,6	<p>“Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо”-нд 0-17 насны 16752 хүүхэд хамруулахаас 90-ээс доошгүй хувийг, насанд хүрэгчдийн 4 насны багцын үзлэгт хамрагдвал зохих нийт 30790 хүнээс 30-аас доошгүй хувийг хамруулахаар төлөвлөлт хийгдлээ. Урьдчилан сэргийлэх үзлэгт 16,7 хувийг хамруулсан байна.</p>	64,7

2.1.1.4	Арга хэмжээ: Өвөр монголын өөртөө засах орны уламжлалтын эмчилгээ, оношлогооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах.	2021-2024	-	Орон нутагт үзлэг зохион байгуулсан эсэх /Тийм-1, Үгүй-2/	2021	2	1	Хугацаа болоогүй.	ХБ
				Үзлэг оношилгоо эмчилгээ хийлгэсэн иргэдийн тоо	2021	0	6500	Хугацаа болоогүй.	ХБ
2.1.1.5	Арга хэмжээ: Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх.	2021-2024	Улсын төсөв 6515950	Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь	2021	88,5	88,5	Эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний төрлийн дагуу зайлшгүй шаарлагатай эм болон эмийн чанар аюулгүй байдлыг ханган тасралтгүй хүртээмжтэй хүргэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүллээ. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 81,5, Амин чухал эмийн хангалт 91,2 хувьтай байна. Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь 86,3	100
		2021-2024		Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь	2021	87	87,5	Төлбөрийг нь төр хариуцах эмийг 2022 оны эхний 5 сарын байдлаар 7 оношоор 22 нэр төрлийн эм тариаг 302 хүнд 6.515.950 төгрөгний эмийг олгоод байна. Нийт төлбөрийг нь төр хариуцдаг эмийг авах иргэнд 100 хувь олгоод байна.	100

2.1.2	Зорилт Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна.	2021-2024	-	Эхийн эндэгдэлийн түвшин	2021	0	0	Жирэмсний хяналтын чанарын сайжруулах ажлын хүрээнд аймгийн төвийн 2 өрх, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг “Ажлын байрны дадлагажуулах 10 хоног”-ийн сургалтад цахимаар 2, танхимын сургалт 1 удаа тус тус хамрууллаа. Жирэмсний хяналтад шинээр 237 жирэмсэн эх хамрагдснаас жирэмсний эрт үеийн хяналт 94,5 хувьтай байна. Эхний 4 сарын байдлаар нийт 212 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 96,2 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрж, жирэмсэн төрөх, төрсний дараах үеийн хүндрэл бүртгэгдээгүй. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. Жирэмсний эрт үеийн хяналт 94,5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ промилль	2021	15,2	14,1	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 4,8 промилль байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,0 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	100
				Сурфактант эмчилгээ хийсэн тоо	2021	2	3	Сурфактант эмчилгээ хийх тохиолдол гараагүй болно.	100
,2.1.2.1	Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах	2021-2024	-	Эхчүүдийн амрах байраар амарсан эхийн тоо	2021	262	270	Эхчүүдийн амрах байранд 32 эх амарч 294 ор хоног ашигласан байна.	26,6
2.1.2.3	Арга хэмжээ: Сумдад 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх сувилал ажиллуулах.	2021-2024	-	Сувиллын тоо	2021	20	25	Аймгийн 0-5 насны нийт хүүхдийн 37,7 хувьд өсөлт хөгжилтийг тодорхойлж хоол тэжээлийн дутагдалтай хүүхэд бүртгэгдээгүй.	100

2.1.3	<p><u>Зорилт</u> Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ.</p>	2021-2024	Хандив тусламж 79,8 сая УТ 519,2 сая	Хэрэглэгчийн үнэлгээний хувь	2021	93,0	92,6	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн үйл ажиллагаанд зориулан 440,0 сая төгрөгийн Зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 33 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 88,9 сая төгрөгийн шүдний кресло/ком/, автоклав, биохимийн аппарат зэрэг 12 төрлийн тоног төхөөрөмж, “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 20,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олголоо. Нийт 350 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэхэд эерэг үзүүлэлт өсөөгүй, муу үзүүлэлт 0,1 хувиар буурсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу QR код уншуулан иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч байна. Хэрэглэгчийн үнэлгээний сайн үзүүлэлт 89,3 хувьтай байна</p>	100
2.1.3.1	<p><u>Арга хэмжээ:</u> Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологээр хангана.</p>	2021-2024	УТ 60,0 сая	Мобайль технологээр хангагдсан сумын тоо	2021	0	10	<p>Мобайль технологээр хангах үйл ажиллагааны хүрээнд Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгний төсөвтэйгөөр төрийн худалдан авах газарт тендер зарлагдаж байна.</p>	ХБ

2.1.3.2	<u>Арга хэмжээ:</u> Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх.	2021-2024	ЭМДС 7,4 тэрбум	Нэр төрлийн тоо	2021	13	13	Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд 2021 оны 3 сараас эхлэн шилжиж 13 нэр төрлөөр эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна. Өрх,сумын эрүүл мэндийн төвүүд 2022 оноос эхлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжүүлээ.	100
				Санхүүжилтын гүйцэтгэлийн хувь	2021	91,0	91,5	Санхүүжилтийн гүйцэтгэлийн 100 хувь.	100
2.1.3.3	<u>Арга хэмжээ:</u> Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах.	2021-2024	-	Яаралтай тусламжийн цэгийн тоо	2021	3	3	Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад нийт яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулснаар авто осол 4, бусдад зодуулсан 3, хугарал бэртэл 5, нохойд уруулсан 3 ,түлэгдэлт 5, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 3, угаартсан 1 тус тус чиглэлээр нийт 24 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.	100
2.1.3.4	<u>Арга хэмжээ:</u> Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох	2021-2024	Хандив тусламж 20,9	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2021	55,3	56	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжид 2 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хандив тусламжаар олголоо. Яаралтай тусламжийн зөөврийн тоног төхөөрөмжийн хангалт 71%-тай байна.	100
			УТ 15,2	Тоноггосон тоо	2021	3	3	Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиньг 15,2 сая тоног төхөөрөмжөөр тоноглолоо.	100
			УТ 44,9 сая	Машины хангалтын хувь	2021	92	93	Түргэн тусламжийн автомашин дутагдалтай байсан Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 44,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин шинээр олголоо. Автомашины хангалтын хувь 93,0 хувьд хүрлээ.	100

2.1.3.5	<u>Арга хэмжээ:</u> Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах.	2021-2024	УТ 34,0 сая	2 догч шатлалын эмнэлэгээс онлайнар зөвлөгөө авсан тоо	2021	15	20	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад утсаар 49 удаагийн нарийн мэргэжлийн зөвлөгөө өгч, 12 удаагийн цахим сургалтыг зохион байгууллаа.	37,5
			УТ 34,0 сая	Компьютерийн тоо	2021	66	39	Эрүүл мэндийн газар, 15 сумын эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 34 сая төгрөгийн үнэ бүхий 1 суурин компьютер, 15 зөөврийн компьютерээр хангагдсан.	47,0
2.1.3.1	<u>Дэд зорилт</u> Эмнэлгүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	2021-2024	Хандив тусламж 79,8 сая УТ 519,2 сая	Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2021	87,0	87,9	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн үйл ажиллагаанд зориулан 440,0 сая төгрөгийн Зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 88,9 сая төгрөгийн шүдний кресло/ком/, автоклав, биохимийн аппарат зэрг 12 төрлийн тоног төхөөрөмж, “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 20,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олголоо. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьд хүрлээ.	100
2.1.3.1.1	<u>Арга хэмжээ:</u> Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих.	2021-2024	-	Шинээр барьсан эмнэлгийн барилгын тоо	2021	12	13	Өндөршил, Луус, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр бариулахаар санал хүргүүлж, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн программд шивүүлж орууллаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгын үйл	ХБ

								ажиллагаа 85,0 хувьтай байна. Ингэснээр нийт эмнэлэг, эрүүл мэндийн төвийн барилгуудын 100 хувь шинэчлэгдэнэ.	
2.1.3.1.2	Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлгийн амбулатори, УАУ-ын төв, ЗӨСТөв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар, Боржгонмандал, Өлзийтмандал, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвүүдэд өргөтгөл хийх	2021-2024	-	Засвар хийсэн эмнэлгийн тоо	2021	0	3	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын засварыг 2023 оны төсөв оруулахаар аймгийн Засаг дарга хариу өгсөн. Одоо зураг төслийн үйл ажиллагаа хийгдэж байна. УАУ-ын төв, ЗӨСТөв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудын их засвар 2024 оны төсөв суутгахаар болсон.	ХБ
				Өргөтгөл хийсэн эмнэлгийн тоо	2021	0	1	Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл хийхээр 2023 онд суулгахаар болсон.	ХБ
2.1.3.1.3	Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах.	2021-2024	Хандив тусламж 17,5 сая, Улсын төсөв 88,9 сая	Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2021	85,6	86,0	Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 88,9 сая төгрөгийн шүдний кресло/ком/, автоклав, биохимийн аппарат зэрэг 12 төрлийн тоног төхөөрөмж, “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олголоо. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувь боллоо.	100

		2021-2024	Хандив тусламж 2,5 сая Улсын төсөв 470,0	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2021	91,8	92,0	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн үйл ажиллагаанд зориулан 440,0 сая төгрөгийн Зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппаратаар хангалаа. “Хүннү ресорус” ХХК-ны хөрөнгө оруулалтаар 2,5 сая төгрөгийн Хүчилтөрөгч өтгөрүүлэгч олголоо. Зооноз өвчин судлалын төвд ариутгал халдваргүйтгэл зориулан 500100 төгрөгийн автомакс улсын төсвөөр худалдан авсан. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 92,0 хувь	100
2.1.3.1.4	<u>Арга хэмжээ:</u> Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх.	2021-2024	-	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай ЭМБ-ын эзлэх хувь	2021	86,7	87,0	Хугацаа болоогүй. 2,3-р улиралд хийгдэнэ.	ХБ
2.1.4	<u>Зорилт:</u> Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд 97.5 хувьд хүргэнэ.	2021-2024	-	Хүний нөөцийн хангалтын хувь	2021	96,8	96.8	Хүний нөөцийн хангалт 2022 оны байдлаар 94,5%-тай байна.	100
2.1.4.1	<u>Арга хэмжээ:</u> Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах	2021-2024	УТ 12.0	Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь	2021	42,0	42,1	Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын орон сууцны судалгааг шинэчлэн гаргалаа. 2022 оны байдлаар 602 албан хаагч хамрагдаж, гэрт 281 буюу 46.6%, орон сууцанд 274 буюу 45.5%, бусад буюу 7.9% эзлэж байна. Дэлгэрцогт, Говьугтаал, Өндөршил сумдад ажиллаж буй эмч нарын орон сууцны асуудлыг шийдвэрлэн ажиллуулж	100

								байна. Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь 45,5	
2.1.4.2	<u>Арга хэмжээ:</u> Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх.	2021-2024	УТ 25,0 сая	Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь	2021	94,8	94,5	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нарийн мэргэжлийн 71 эмч ажиллахаас одоогоор 68 ажиллаж хангалт 95.8%-тай байна.	100
				мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо	2021	17	17	Эхний 5 сарын байдлаар Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг болон Адаацаг, Дэлгэрхангай сумдад эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал, дүрс оношлогоо, зүү эмчилгээний нарийн мэргэшлийн эмч, аймгийн Нэгдсэн эмнэлэгт дотор 1, сэтгэц 1, яаралтай тусламж 1, сэргээх засах 1, Сайнцагаан, Адаацаг сумдын эрүүл мэндийн төвүүдэд дархлаажуулалт, сэргээн засахын сувилагч нарыг мэргэжил олгох сургалтад хамруулж одоогийн байдаар нийт 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургаж байна.	100
2.1.4.2.1	<u>Арга хэмжээ:</u> Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх.	2021-2024	УТ 13,0 сая	Сувилагч мэргэжилтний хангалтын хувь	2021	94,0	94,5	Эхний хагас жилийн байдлаар сувилагчийн хангалт 93.5%, лавлагаа шатлалд 95.7%, анхан шатлалд 91.3%-тай байна. Глобал Удирдагч дээд сургуультай хамтран ажиллаж гэрээний дагуу Адаацаг 3, Сайнцагаан 5, Говь-Угтаал, Луус, Хулд, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдад тус бүр 1 нийт 13 сувилагч одоо төгсөж ирж ажилласанаар хангалт 93,5%-тай болж 2.5%-иар нэмэгдэнэ.	90
2.1.4.2.2	<u>Арга хэмжээ:</u> “Ахмадын ордон”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-д ахмад настнууд болон хөгжлийн	2021-2024	-	Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн тоо	2021	11	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн хүний нөөц бэлтгэхэд ажил эрхэлж байгаа болон эрхлэх боломжтой хүний нөөцийн судалгаа гаргаж АЗДТГ-т хүргүүлээ.	100

	бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх.							Шаардлагатай сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх 1 хүнийг бэлтгэхээр саналыг хүргүүллээ. 2022 оны 9 сард сургалтад хамрагдана. Одоо Адаацаг суманд сэргээн засах тусламж үйлчилгээний сувилагчийг бэлтгэж байна.	
2.1.4.3	<u>Арга хэмжээ:</u> Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч эмнэлгийн тусгай мэрэгжилтнүүдийг туршлага судлах сургалтад хамруулах	2021-2024	-	Гадаад сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо	2021	0	54	Нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдсон. 2022-2025 онд гадаадад хамрагдах судалгааг Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ. Нэгдсэн эмнэлгийн мэс заслын 1 эмчийг мэргэшлийн дагуу 1,5 жилийн хугацаатай Япон улсад сургалтад хамруулж байна.	ХБ
Хэрэгжилтийн дундаж									89,6

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН: ХШУДА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.АЛТАНТӨГС

П.ОЮУНЧИМЭГ